



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 10 сарын 16 өдөр

Дугаар А/729

Булган сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймаг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2022 оны хамтын ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх оёдлын иж бүрэн цехийн засварын ажлыг “Соотон чоно” ХХК-тай 59,411,658 (тавин есөн сая дөрвөн зуун арван нэгэн мянга зургаан зуун тавин найм) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2.Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

3.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Соотон чоно” ХХК-д даалгасугай.

4.Тус ажлыг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2022 оны хамтын ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2023 оны 10 сарын
16.. өдрийн дугаар захирамжийн хавсралт

№	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	Магадлашгүй ажил	927,447	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн албаны зардал	927,447	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөв зохиогчийн хяналтын зардал	463,723	Ү.Бямбасүрэн
4	Инженер хайгуул зураг төслийн ажлын дүн	6,000,000	Ү.Бямбасүрэн
5	Алданги	Хоногт гэрээний үнийн 0.1 хувь, нийт алданги гэрээний үнийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Д.Баясгалан
6	Ажил гүйцэтгэх хугацаа	30 хоног	Ү.Бямбасүрэн